

## **Гэр бүлийн эрх зүйн харилцаа, түүний зохицуулалтыг боловсронгуй болгох нь /Гэр бүлийн тухай хууль болон Гэр бүлийн хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуулийн өргөн мэдүүлсэн төслийн шүүмж/\***

Түвшинжаргалын АНУЖИН\*\*

Эрдэнэ-Очирын ЖАВЗМАА\*\*\*

---

### I. Удиртгал

### II. Үндсэн хэсэг

1. Хүүхэд оролцсон гэр бүлийн маргаанд сэтгэл зүйч зайлшгүй оролцох тухай
2. Гэр бүлийн хүчирхийлэл үйлдэх гэмт хэргийг гэрлэлт цуцлах маргаантай хамт шийдвэрлэх
3. "Гэр бүлтэй адилтгах орчин"-г тодорхойлох нь
4. Хууль хоорондын тодорхойгүй байдал
5. Гэр бүлийн эрх зүйн маргааныг шийдвэрлэх шүүх бүрэлдэхүүн

### III. Харьцуулсан судалгаа

### IV. Дүгнэлт, санал

---



\* Энэхүү бүтээл нь Төв аймагт шүүх байгуулагдсаны түүхт 100 жилийн ойг тохиолдуулан Монгол Улсын гавьяат хуульч Ч.Доржгочоо, М.Могноон нарын нэрэмжит "Шилдэг илтгэл" шалгаруулах уралдааны "Оюутан" ангилалд II байр эзэлсэн болно.

\*\* Монгол Улсын их сургуулийн Хууль зүйн сургуулийн 4 дүгээр түвшний оюутан.

\*\*\* Монгол Улсын их сургуулийн Хууль зүйн сургуулийн 4 дүгээр түвшний оюутан.



## Гэр бүлийн эрх зүйн харилцаа, түүний зохицуулалтыг боловсронгуй болгох нь /Гэр бүлийн тухай хууль болон Гэр бүлийн хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуулийн өргөн мэдүүлсэн төслийн шүүмж/



**Түвшинжаргалын АНУЖИН** Монгол Улсын их сургуулийн  
Хууль зүйн сургуулийн 4 дүгээр  
түвшний оюутан.

**Эрдэнэ-Очирын ЖАВЗМАА** Монгол Улсын их сургуулийн  
Хууль зүйн сургуулийн 4 дүгээр  
түвшний оюутан.

**Хураангуй:** Хүн төрөлхтний нийгмийн анхдагч бүлэг нь гэр бүл байдаг. Энэ утгаараа гэр бүлийн харилцаа нь хүний амьдралын суурь орчин болохын сацуугаар Үндсэн Хуулиар хамгаалагдсан гол харилцаа юм. Тухайлбал, Үндсэн Хуулийн 16.13-т халдашгүй байх эрхийг дурдахдаа "...иргэний хувийн ба гэр бүлийн..." гэж тусгасан. Энэ зэргээс авч үзвэл, хүн төрөлхтний хамгийн нандин хийгээд чухал, халдашгүй байх харилцаа гэр бүл байх нь гарцаагүй юм.

Гэр бүлийн эрх зүй нь бусад салбар эрх зүйтэй харьцуулахад албадлага хэрэглэх шинж харьцангуй бага, нийгмийн эмзэг бүлэг буюу хүүхэд, эцэг, эх зэргийн харилцааг зохицуулдаг тул илүү хувийн шинж чанартай. Гэвч манай улсын хувьд ардчилсан дэглэмийг тогтоогоод тун удаагүй байх цаг хугацаанд буюу 1999 онд Гэр бүлийн эрх зүйн харилцааг зохицуулж, харин гэр бүлтэй холбогдох хэрэг, маргааныг холбогдох эрүү, иргэн, захиргааны шүүхээр хянан хэлэлцүүлж байсан. Хэдийгээр тухайн хуульд нийтдээ 8 удаагийн нэмэлт, өөрчлөлт оруулж эрх зүйн зохицуулалтыг боловсронгуй болгож байсан боловч нэгэнт 27 жилийн хугацаа өнгөрөхөд гэр бүлийн зарим харилцаа зохицуулагдаагүй үлдсээр байгаа юм. Үүний сацуугаар гэр бүлийн маргааныг иргэн, эрүү, захиргааны шүүхээр хянан хэлэлцүүлэхэд тухайн харилцааны гол онцлог буюу хүүхдийн эрх, ашгийг дээдлэх, нэн тэргүүнд тавих зарчмыг зохих процессын хуулийн зохицуулалтад байхгүйн улмаас баримтлахгүй байх тул энэ онцлог шинж бүхий харилцааг илүү боловсронгуй суурь зарчимтай нийцүүлэх шаардлага үүссэн.

Монгол Улсын Засгийн газраас Гэр бүлийн тухай хуулийг 2023 оны 11-р сарын 14-ний өдөр, харин Гэр бүлийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулийг 2025 оны 11-р сарын 14-ний өдөр тус тус өргөн мэдүүлсэн. Ингэхдээ зарим төрлийн эрх зүйн харилцааг орхигдуулж, үүний улмаас зарим хэм хэмжээг илүү боловсронгуй болгох шаардлага үүссэн. Тиймээс судлаач оюутнуудын зүгээс социаль судалгааны эмпирик арга зүйг ашиглан өргөн мэдүүлсэн төслийн асуудлуудыг хөндөж, шийдэл эрэлхийлэхийг зорьсон болно.

### Түлхүүр үг

Гэр бүл, хэрэг хянан шийдвэрлэх, сэтгэл зүйч, гэр бүлийн хэрэг, гэр бүлтэй адилтгах орчин, хүчирхийлэл, иргэдийн төлөөлөгч, хаалттай, шүүх бүрэлдэхүүн, өргөн мэдүүлсэн төсөл

## I. УДИРТГАЛ

### 1. Сэдвийн судлагдсан байдал

Энэхүү эрдэм шинжилгээний илтгэлийн гол судлагдахуун нь өргөн мэдүүлсэн хуулийн төсөл буюу "Гэр бүлийн тухай" хууль(цаашид ГБтХ) болон "Гэр бүлийн хэрэг хянан шийдвэрлэх тухай" хууль(цаашид ГБХШХШтХ) юм. Тус хоёр бие даасан хууль тогтоомжийн гол асуудлыг нээн илрүүлэх, санал дэвшүүлэх нэг сэдэвт бүтээл, сурах бичиг, гарын авлага зэрэг нь Монгол Улсын нутаг дэвсгэрийн хүрээнд тун ховор буюу илэрц байхгүй байна. Харин судалгаа болон шүүх, арбитрын нэгдсэн хайлтын систем(Legaldata)-д 2026 оны 03 дугаар сарын 10-ны нөхцөл байдлаар нийт 2245 бүтээлийн 21 бүтээл нь гэр бүлийн эрх зүйтэй холбогдож байна. Мөн 20 бүтээлийг зохицуулалтын зүйлээр нь ангилан авч үзвэл, гэрлэлтийн гэрээтэй холбогдох бүтээл 5, хүүхэд үрчлэлт, тэтгэлгийн тухай 6, гэр бүлийн хүчирхийллийн тухай 6, сэтгэл санааны хохирлын тухай 1, гэр бүлийн дагнасан шүүхийн хэрэгцээ, шаардлагын тухай 1, эвлэрүүлэн зуучлах тухай 1 тус тус байршсан. Үүнээс үзвэл, өргөн мэдүүлсэн хуулийн төсөл дээр төвлөрөн судалсан бүтээл боловсролын салбарын эргэлтэд ороогүй байна.

### 2. Сэдэв сонгосон үндэслэл

Гэр бүлийн эрх зүйн харилцаа нь бусад салбар эрх зүйтэй харьцуулахад нийгмийн бүлгийн дотоод болон гадаад харилцааг зохицуулдгаар онцлогтой. Өөрөөр хэлбэл, хүүхдийн эрх, ашгийг нэн тэргүүнд тавьж аливаа үйл ажиллагааг түүнд нийцүүлэх зарчмыг баримталдаг нь бусад албадлагын шинжтэй эрх зүйн хэм хэмжээнээс бүрдэх хууль тогтоомжоос ялгаатай байдлыг илэрхийлдэг.

Аливаа нийгмийн харилцаа хийгээд түүнд тулгамдаж буй асуудал нь цаг хугацаа хувьсан өөрчлөгдөхтэй зэрэгцэн шинэчлэгдэж байдаг. Харин манай улсын хувьд энэ харилцааг зохицуулах гол хууль болох ГБтХ нь 1999 онд батлагдсан байхын зэрэгцээ 8 нэмэлт, өөрчлөлт орсон боловч энэхүү онцлог харилцааг хангалттай хэмжээнд бүрэн зохицуулж чадахгүй байсаар ирсэн. Үүнээс улбаалан Монгол Улсын Засгийн газар онол, практикийн тулгамдсан асуудал буйг судлан авч үзээд, 2025 онд ГБтХ-ийг өргөн мэдүүлсэн байдаг. Харин үүнийг хянан хэлэлцэх буюу процессын асуудлыг эрүү, иргэн, захиргааны хэрэг хянан шийдвэрлэх хуулиас тусдаа ялган үзэж ГБШХШтХ-ийг мөн онд өргөн мэдүүлсэн. Хэдийгээр хуучин хуульд шинэчлэл оруулж, өргөн мэдүүлсэн боловч зарим эрх зүйн зохицуулалтыг боловсронгуй болгох шаардлага үүссэн. Өөрөөр хэлбэл, өргөн мэдүүлсэн хуулийн төсөл нь хууль тогтоомжийн тухай хуулийн 4.1.5-т дурдсаны дагуу судалгаа, шинжилгээнд үндэслэсэн байх зарчмыг баримтлаагүй гэх үндэслэлт нөхцөл байдал бий болсон. Тиймээс энэхүү хүн төрөлхтний анхдагч бүлгийг зохицуулсан харилцаа, түүнийг шийдвэрлэх процесс ажиллагааны эрх зүйн орчныг судлах, дахин сайжруулахын тулд энэхүү эрдэм шинжилгээний илтгэлийг бичсэн болно.

### 3. Судалгааны зорилго

Тус эрдэм шинжилгээний илтгэлийн гол зорилго нь Монгол Улсын Засгийн газрын 2025 оны 11-р сард өргөн мэдүүлсэн ГБтХ болон ГБХШХШтХ-ийн төслийн



зарим эрх зүйн зохицуулалтыг боловсронгуй болгох үндэслэлийг тогтоох, зохицуулагдаагүй харилцааг нээн илрүүлэх, илрүүлсэн асуудал бүрд санал дэвшүүлэхийг зорьсон болно.

#### 4. Судалгааны арга, зүй

Энэхүү эрдэм шинжилгээний илтгэлийг социаль судалгааны тоон болон чанарын арга зүйг ашиглан хийж гүйцэтгэсэн болно. Чанарын судалгааны арга зүйг өөрөөр эмпирик судалгааны арга гэх бөгөөд шаардлагатай онол болон бусад мэдээллийг ашиглан ерөнхий дүгнэлтэд хүрэх зорилготой.<sup>1</sup>

- Баримт бичгийн шинжилгээ: Холбогдох сурах бичиг, өөрийн орны болон бусад улсын хууль тогтоомж, эрх зүйн толь бичиг гэх мэтчилэн эрх зүйн эх сурвалж дээрх агуулга, догол мөр, үг зүйн утга зэргийг ойлгон нэгдсэн дүгнэлтэд хүрэхийн тулд ашигласан.
- Тоон судалгааны арга: Асуудал дэвшүүлж, түүнийг шийдвэрлэх саналыг тоон өгөгдлийн зүй тогтол, давтамж хоорондын хамаарлыг судалж үндэслэл бүрдүүлэхэд ашигласан.

## II. ҮНДСЭН ХЭСЭГ

Өмнөх хэсэгт дурдсанчлан гэр бүлийн эрх зүйн харилцаа нь ҮнХ-ийн 16.13-т зохицуулагдсан халдашгүй байх эрхтэй холбогдохын зэрэгцээ хүний анхдагч бүлгийн харилцааг зохицуулдаг онцлогтой. Энэ салбар эрх зүйн харилцаагаар нийгмийн бүлэг хүмүүсийг бүхэлд зохицуулахад түүний мөн чанар оршино. Тухайлбал, өсвөр насны хүүхэд, эцэг, эх байх эрх, хөдөлмөрийн чадваргүй гэр бүлийн гишүүн, ахмад настан, хөгжлийн бэрхшээлтэй гэр бүлийн гишүүн зэрэг субъектүүд багтана. Тиймээс нийгмийн эмзэг болон хувь хүний нийгэмд эзлэх статусыг тодорхойлох эрх зүйн орчин, харилцааг бүрэлдүүлэх ГБтХ<sup>2</sup> болон ГБХХШтХ-ийн төслийг<sup>3</sup> тус бүлэгт нарийвчлан судалсан болно.

Ийнхүү холбогдох хуулийг шинэчлэн найруулж төсөл боловсруулахад хууль зүйн хэлбэрийн болон агуулгын 6 алдааг гаргасан гэж үзсэн тул судлаач оюутнуудын зүгээс дараах хэсэгт алдаа гэж үзэх үндэслэлүүдийг тус бүрчлэн тайлбарлаж, асуудлыг шийдвэрлэх боломжит саналыг дэвшүүлсэн болно.

### 1. Хүүхэд оролцсон гэр бүлийн маргаанд сэтгэл зүйч зайлшгүй оролцох тухай

Хүүхэд гэр бүлийн хүчирхийллийн олон хэлбэрээр хохирох бүрийд сэтгэл санааны шаналал зовуур үүсэж улмаар хүүхдийн хэвийн өсөлт хөгжилд сөргөөр нөлөөлдөг гэж криминологийн шинжлэх ухаанд үздэг.<sup>4</sup> Эрсдэлт нөхцөлд байгаа

<sup>1</sup> Penn state university libraries, "Empirical Research in the Social Sciences and Education," Цахим эх сурвалжийг бүрэн эхээр нь үзэх холбоос: <https://guides.libraries.psu.edu/emp> (Сүүлд үзсэн: 2025.03.15).

<sup>2</sup> Гэр бүлийн тухай хуулийн төслийг Монгол Улсын Засгийн газар 2025 оны 11-р сарын 24-ний өдөр өргөн мэдүүлсэн байх бөгөөд 11 бүлэг, 87 зүйлтэй.

<sup>3</sup> Гэр бүлийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулийн төслийг Монгол Улсын Засгийн газар 2025 оны 11-р сарын 14-ний өдөр өргөн мэдүүлсэн байх бөгөөд 5 бүлэг, 40 зүйлтэй.

<sup>4</sup> С.Жанцан, *Криминологи*, 2000

хүүхэд<sup>5</sup> болон хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанд оролцогч хүүхэд<sup>6</sup> нь Гэр бүлийн хүчирхийллийн тухай хуулийн 26.1 дүгээр зүйлийн 1 дэх хэсэг, Хүүхэд хамгааллын тухай хуулийн 23 дугаар зүйлийн 1 дэх хэсэг, 23.4 дүгээр хэсгийн 4 дэх заасны дагуу сэтгэл зүйн үйлчилгээ үзүүлэх эрх зүйн зохицуулалтыг боловсруулсан байх боловч гэр бүлийн эрх зүйн маргааны хохирогч болсон хүүхдүүд тухай үе шат бүрд сэтгэл зүйчтэй ажиллах тогтсон хандлага нэгэнт суурьшаагүй болохыг график№1 дээр дэлгэрэнгүй харуулсан байна.<sup>7</sup>

**График 1. Насанд хүрээгүй хохирогчид учирсан сэтгэл зүйн эмчилгээ**



Сэтгэл зүйн үйлчилгээ аваагүй хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны оролцогч, хохирогч хүүхэд тухайн хэргийг шүүхийн шатанд хянан шийдвэрлэхэд хүүхдийн сэтгэл зүйн нөхцөл байдалд хүндрэл учрах боломжтой. Мөн үүгээр хязгаарлагдахгүй өсвөр насны сэжигтэн, яллагдагч, шүүгдэгч нь эрүүгийн процессын шүүхийн өмнөх болон шүүхийн ажиллагааны үед өөрийн мэдэж буй аливаа үйл баримтыг илтгэх, мэдүүлэг өгөхөд мөрдөгч, шүүгч болон бусад хэрэг хянан шийдвэрлэж буй эрх мэдэл бүхий албан тушаалтнуудын асуултыг **"хэт мэдрэмтгий"** байдлаар хүлээж авах, үүний үр дагаварт сэтгэл зүйн гэмтэл учрах өндөр эрсдэлтэй.

<sup>5</sup> Хүүхэд хамгааллын тухай хуулийн 4.1.4-т заасны дагуу **"эрсдэлт нөхцөлд байгаа хүүхэд"** гэдэг нь амь нас, эрүүл мэнд, аюулгүй байдал, хөгжих хэвийн орчин алдагдсан хүүхэд, хүчирхийлэлд өртсөн, эсхүл өртөх нөхцөлд байгаа хүүхэд, эцэг, эх, асран хамгаалагч, харгалзан дэмжигчгүй хүүхэд, гамшиг, гамшигийн онцгой нөхцөл байдалд байгаа хүүхдийг ойлгоно.

<sup>6</sup> Хүүхэд хамгааллын тухай хуулийн 4.1.5-т заасны дагуу **"хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанд оролцогч хүүхэд"** гэж гэмт хэрэг, зөрчлийн хохирогч, гэрч хүүхэд, өсвөр насны сэжигтэн, яллагдагч, шүүгдэгч, зөрчилд холбогдогч хүүхэд, зөрчил үйлдэж шийтгэгдсэн, эрүүгийн хариуцлага хүлээсэн, сургалт-хүмүүжлийн тусгай байгууллагаас суллагдсан хүүхэд, иргэний болон захиргааны хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанд эрх, хууль ёсны ашиг сонирхол нь хөндөгдөж байгаа хүүхэд

<sup>7</sup> Улсын Ерөнхий Прокурорын газрын дэргэдэх сургалт, судалгааны хүрээлэн, *Гэр бүлийн хүчирхийллийн улмаас хүүхэд хохирсон гэмт хэргийн гаралт, шийдвэрлэлт, шалтгаан, нөхцөл*, 2022. 64 дэх тал.



### Шигтгээ 1. Өсвөр насны хүүхдийн сэтгэл судлалын онол

**"Өсвөр насны эгоцентризм"** гэх онолын үзэл баримтлалын дагуу өсвөр насны хүүхдийн өөрийгөө олох үйл явц хурдсаж, нийгмийн хүлээлтийг эрхэмлэх, өөрийгөө анзаарах, бусдын үнэлгээнд хэт мэдрэмтгийн болох, аливаад хэт эмзэглэх хандлагатай байдаг.

**-David Elkind. Child Development: Egocentrism in Adolescence.<sup>8</sup>**

**"Сэтгэл, нийгмийн хөгжлийн"** онолын үзэл баримтлалын дагуу өсвөр насны үед хүүхэд "Би хэн бэ?" гэдэг асуулттай өдөр бүр тулгарч, өөрийн үнэлэмжийг бий болгодог. Үүний дагуу бусдын асуулт, шүүмжлэлийг "намайг үгүйсгэж байна" гэж хүлээж авах тохиолдол байдаг.

**-Identity vs Role Confusion – Erikson's Theory of Teenage Identity Crisis Explained<sup>9</sup>**

Дээрх практик хэрэгцээ, шаардлага болон онолын үзэл баримтлалд дурдсаны дагуу өсвөр насны хүүхдийн сэтгэл зүйн байдал нь мэдрэмтгий буюу аливаад эмзэглэх, улмаар бодит бус нөхцөл байдлыг авчрах эрсдэлтэйг харуулж байна. Гэвч өргөн мэдүүлсэн ГБХХШТХ-ийн 13.7 дугаар зүйлд заасны дагуу шүүх хуралдаанд **сэтгэл зүйч оролцуулах эсэх тухай** асуудлыг шүүх шийдвэрлэхээр зохицуулсан. Энэ нь хүүхэд оролцсон маргаан бүрд бус зөвхөн гэрлэлт цуцлахад, цаашлаад шүүгч шаардлагатай тохиолдолд гэх арга замаар сонгох боломжийг хэрэгжүүлэх нөхцөл байдал бий болгосон. Харин дээр дурдсан судалгааны хүрээнд, аливаа эрх зүйн маргаанд оролцож буй хүүхэд болгон шүүхийн болон шүүхийн өмнөх шатанд сэтгэл зүйчтэй ажиллах шаардлагатайг харуулж байна.

Тиймээс хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааг шударга, үнэнд нийцүүлэх зарчмын дагуу хэрэгт хамаарал бүхий хүүхэдтэй харьцах чадвартай хүүхдийн сэтгэл зүйчийг шүүхийн орон тоонд багтааж **ONE CHILD-ONE PSYCHOLOGIST** зарчмыг баримтлах нөхцөл үүсэж байна. Ингэхдээ тухайн шүүхэд ажиллах хүүхдийн сэтгэл зүйч нь зохих хууль зүйн мэдлэгтэй байх шалгуурыг тавивал зохистой.

### Шигтгээ 2. Сэтгэл зүйч мэргэжлийн боловсон хүчин


Боловсролын яамнаас мэдээлснээр 1992 оноос хойш 2021 он 600 орчим сэтгэл зүйч мэргэжилтэй боловсон хүчин их, дээд сургууль төгссөн байх боловч мэргэжлээрээ 50–55% нь ажилладаг болохыг мэдээллэсэн. Үүнээс үзэхэд мэргэжлээрээ ажиллахгүй байгаа боловсон хүчин дундаас шүүх эрх мэдэл бүхий байгууллагад ажиллах сонирхол бүхий сэтгэл зүйчийг ашиглах менежмент бий болгож ажиллах хүчийг нэмэгдүүлэх боломжтой.

<sup>8</sup> Kristine D. Frankenberger, "Adolescent egocentrism: a comparison among adolescents and adults," 2000.

<sup>9</sup> Saul McLeod, *Erik Erikson's Stages of Psychosocial Development*, 2025.

## 2. Гэр бүлийн хүчирхийлэл үйлдсэн гэмт хэргийг гэрлэлт цуцлуулах хүсэлттэй хамт шийдвэрлэх

График 2. Гэр бүлийн хүчирхийлэл үйлдэх гэмт хэргийн шүүхээр хянан шийдвэрлэсэн тоон мэдээлэл



Өргөн мэдүүлсэн ГБХХШТХ-тай хамт өргөн мэдүүлсэн хуулийн төсөлд "Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай" хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах хууль тусгагдсан байх бөгөөд мөн төслийн 15 дугаар хэсэгт "...гэрлэлт цуцлуулах тухай нэхэмжлэл гаргасан шалтгаан нь Гэр бүлийн хүчирхийлэл үйлдэх гэмт хэрэг бол прокурор, оролцогчийн саналыг үндэслэн Нийслэл дэх Гэр бүл, хүүхдийн хэргийн анхан шатны тойргийн шүүхээр уг хэргийг хянан шийдвэрлүүлэхээр Улсын дээд шүүхийн Эрүүгийн хэргийн танхимын тэргүүн хэргийн харьяаллыг өөрчлөн тогтоож болно" гэж заажээ. Үүнээс үзвэл, уг эрх зүйн зохицуулалтын дагуу гэр бүл цуцлах болон Гэр бүлийн хүчирхийллийн үндэс болсон тохиолдолд хэргийн дарааллыг хэрхэн тогтоох тухай авч эрх олгосон хэм хэмжээг ГББШТХ-ийн төсөлд зохицуулаагүй болох нь илэрч байна. Дээрх хоёр төрлийн эрх зүйн маргааныг нэг шүүхэд харьяалуулахаар ЭХХШТХ-д тусгасан байх боловч Гэр бүлийн хэрэг хянан шийдвэрлэх хуульд үүнтэй холбогдох эрх олгосон хэм хэмжээ байхгүй байгаа нь хууль хэрэгжихэд хүндрэл учирч байна. Тиймээс гэр бүл цуцлалт болон гэр бүлийн хүчирхийлэл үйлдэх гэмт хэргийг Нийслэл дэх Гэр бүл, хүүхдийн хэргийн анхан шатны тойргийн шүүх хянан шийдвэрлэхдээ тус бүрд нь шүүх хурлан товлон шийдвэрлэх, эсхүл нэг шүүх хуралдааны процесс ажиллагааны дагуу хянан шийдвэрлэх зэргийг зохицуулж хэргийн дарааллыг тогтоох нь ач холбогдолтой.

График№2<sup>10</sup> болон график№3<sup>11</sup>-г тус тус харьцуулан авч үзвэл, гэр бүл цуцлах болон гэр бүлийн хүчирхийлэл үйлдэх гэмт хэргийг нэг дор, мэргэжлийн төрөлжсөн шүүхээр хянан хэлэлцүүлэх нь нэг талаас процесс ажиллагааны хэмнэлттэй байх, хурдан шуурхай байх зарчим зэрэг эерэг үр дагаврыг авчрах боломжтой.

## 3. "Гэр бүлтэй адилтгах орчин"-г тодорхойлох нь


Гэр бүлийн эрх зүйн харилцаанд хүүхдийн асран хамгаалагч, харгалзан

<sup>10</sup> Монгол Улсын Дээд Шүүх, "Гэр бүлийн хүчирхийлэл үйлдэх гэмт хэргийг хянан шийдвэрлэх ажиллагаа, тулгамдаж буй бэрхшээл, бодлогын шинэчлэл" (2025.06.24)

<sup>11</sup> "Гэр бүлийн тухай хуулийн шинэчилсэн найруулгын төслийн талаар" Дэлгэрэнгүй танилцуулга. Цахим эх сурвалжийг бүрэн эхээр нь үзэх холбоос: [https://legalinfo.mn/storage/uploads/process/202509/file\\_1759140712100301\\_17143739132592372.pdf#:~:text=\(Сүүлд үзсэн: 2026.03.16\).](https://legalinfo.mn/storage/uploads/process/202509/file_1759140712100301_17143739132592372.pdf#:~:text=(Сүүлд үзсэн: 2026.03.16).)

بصريحه من الخلفه . الخلفه بصريحه

- ### График 3. Гэр бүл цуцлалт



Өөрөөр хэлбэл, асран хамгаалах байгууллагыг жишээ татан авч үзвэл, тухайн хүүхдийн гэр бүл болох тухай ойлголт юм. Тиймээс асран хамгаалах байгууллага болон хуульд дурдсан бусад эрх бүхий этгээдүүдийг "гэр бүл" хэмээн тооцох эсэх, үүнийг томьёолох нэн ач холбогдолтой. Учир нь асран хамгаалагч, харгалзан дэмжигч нь тухайн тодорхой хугацаанд хүүхдийг асрах, асран хамгаалах нь хүүхдийн эсрэг гэмт хэрэг үйлдэх, хуульд заасан үүргийг биелүүлэхгүй байх тохиолдолд хүүхдийн эцэг, эхийн нэгэн адил хариуцлага хүлээх эсэх, эсхүл захиргааны байгууллага тэдгээрт хариуцлага тооцох эсэх нь ойлгомжгүй нөхцөл байдлыг үүсгэж байна. Тиймээс гэр бүлийн адилтгах орчин гэдгийг нэр мөр тодорхойлж, үүнд ямар субъект багтах зэргийг зохицуулснаар дээрх асуудал бүрэн шийдэгдэнэ(*Жишээлбэл, асран хамгаалах байгууллагад амьдарч буй хүүхдийг гэр бүлийн орчинд амьдарч байна гэж үзэн тэнд хүчирхийлэлд өртсөн тохиолдолд тухайн байгууллагын ажилтан ЭХ-д заасан гэр бүлийн хүчирхийлэл үйлдэх гэмт хэргийн субъект болно*). Тиймээс судлаач оюутнуудын зүгээс гэр бүлтэй адилтгах гэдгийг дараах байдлаар тодорхойлсон хувилбаруудыг санал болгож байна.

**Хүснэгт 1. "Гэр бүлтэй адилтгах орчин" гэх хууль зүйн ухагдахууныг тодорхойлсон нь**

|                                           |                                                                                                                                                                                                  |
|-------------------------------------------|--------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------|
| <b>Гэр бүлтэй адилтгах орчин гэдэг нь</b> | Хувилбар№1. Хүүхэд өөрийн төрсөн эцэг, эхийн асрамжид амьдрах боломжгүй нөхцөлд түүнд гэр бүлийн орчинтой адил нөхцөлд асран хамгаалж, халамжилж, хүмүүжүүлэх зорилгоор бүрдүүлсэн орчинг хэлнэ. |
|                                           | Хувилбар№2. Хүүхэд төрсөн эцэг, эхийн асрамжид амьдрах боломжгүй тохиолдолд түүний эрх, ашгийг хангах зорилгоор асран хамгаалж, халамжилж, хүмүүжүүлэхээр зохион байгуулсан орчинг ойлгоно.      |

**4. Хууль хоорондын тодорхойгүй байдал**

Энэхүү хэсгийн хүрээнд судлаач оюутнуудын зүгээс **гэр бүл цуцлалтын** харилцаан дах өргөн мэдүүлсэн хуулийн зохицуулалтуудыг хамруулан авч үзэн дараах эрх зүйн хэм хэмжээний тодорхойгүй байдал, хууль хооронд үүсэж буй зөрчлийг хөндөн шийдэл илрүүлж, шийдлийг эрэлхийлэв.

Гэр бүлийн эрх зүйн хүрээнд гэрлэлт цуцлуулах **нэхэмжлэлийг хэрэгсэхгүй болгох, эсхүл шүүх шууд хянан шийдвэрлэх асуудлыг (хоёр өөр байдлаар шийдвэрлэх)** ГБТХ-ийн шинэчилсэн найруулга болон ГБХШХШТХ-иар зохицуулсан байна.<sup>12</sup>Тухайлбал,

ГБТХ-ийн шинэчилсэн найруулгын 11.2 дугаар зүйлд "

- Эхнэр нь жирэмсэн, эсхүл
- гурван насанд хүрээгүй хүүхэдтэй, эсхүл
- хүүхэд нь хөгжлийн бэрхшээлтэй, эсхүл
- гэрлэгчдийн хэн нэг нь хүндээр өвчилсөн, эсхүл
- хөдөлмөрийн чадвараа хагас, эсхүл бүрэн алдсан тохиолдолд хариуцагч гэрлэлтээ цуцлуулахыг зөвшөөрөөгүй бол гэрлэлт цуцлуулах нэхэмжлэлийг шүүх **хэрэгсэхгүй болгоно"** хэмээн зохицуулсан. "Хэрэгсэхгүй болгоно" гэдэг нь хэрэг маргааныг хянан шийдвэрлэх ажиллагааны явцад гэмт хэргийн шинжгүй, нотлох баримт хангалтгүй, эсхүл хуульд заасан бусад үндэслэлээр хэргийг цаашид үргэлжлүүлэн шалгах шаардлагагүй гэж үзэн, мөрдөн байцаалт болон шүүхийн шатанд хэргийг зогсоох, хаах эрх зүйн үйлдэл юм. Гэвч ГБХШХШТХ-ийн **25.4 дугаар зүйлд "Энэ хуулийн 25.1-д заасан арга хэмжээг дараах тохиолдолд шүүгч авахгүйгээр гэрлэлтийг цуцалж болно:**
  - гэрлэгчид эвлэрэх боломжгүй буюу
  - гэрлэгчдийн хэн нэгний байнгын хүчирхийлэл дарамтаас болж гэр бүлийн гишүүдийн амь нас, эрүүл мэнд болон хүүхдийн хүмүүжилд ноцтой аюул, хор уршиг учирч болзошгүй, эсхүл
  - учирсан нь тогтоогдсон" хэмээн хуульчилсан байна. Эдгээр зохицуулалтыг харьцуулан , холбоо хамаарлын шалтгааныг авч үзвэл уг эсрэг нөхцөлийг

<sup>12</sup> Гэр бүлийн хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай өргөн мэдүүлсэн хуулийн төсөл (2025), 11.2 дугаар зүйл



хэрэгжүүлэхэд давхардал үүсэх боломжтой ба тухайлбал, эхнэр нь жирэмсэн боловч байнгын хүчирхийлэл, дарамтад байдаг, эсхүл хүүхэд нь гурван насанд хүрээгүй боловч гэр бүлийн хүчирхийллийн улмаас хор уршигучирсан тохиолдол байх боломжтой юм. Үүнийг дээрх зохицуулалтын хүрээнд авч үзвэл, ГБТХ-ийн шинэчилсэн найруулгын 11.2 дугаар зүйлд заасны дагуу хариуцагч гэрлэлтээ цуцлуулахыг зөвшөөрөөгүй бол хэргийг хэрэгсэхгүй болгох боломжтой. Гэвч ГБХШХШТХ-ийн 25.4 дүгээр зүйлд шууд цуцлах тухай зохицуулжээ. Үүнээс үзэхэд хууль хоорондын тодорхойгүй байдал, эсхүл аль нь давуу хэрэгжих нь тодорхой бус байх зэрэг асуудал үүсэж байна. Энэ нь нэг талаасаа иргэний ҮНХ-д заагдсан тэгш эрх, сайн дурын үндсэн дээр гэрлэх, нөгөө талаасаа "гэр бүл, эх нялхас, хүүхдийн ашиг сонирхлыг төр хамгаалах" чиг үүргүүд зөрчигдөх эрсдэлтэй. Иймд энэхүү зохицуулалтыг боловсронгуй болгон хуульчлах хэрэгцээ шаардлага үүссэнийг доорх хүснэгтээс харах боломжтой.

**Хүснэгт 2. Гэр бүлийн эрх зүйн харилцаатай холбогдох хэм хэмжээнүүдийг харьцуулсан түүхчилсэн судалгаа**

| Гэр бүлийн тухай хууль /1999 он/                                                                                                                                                   | Гэр бүлийн тухай хууль /2025 он/                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                            | Гэр бүлийн хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай /2025 он/                                                                                                                                                                                                                                                                                                     |
|------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------|-----------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------|--------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------|
| 12.2.Эхнэр нь жирэмсэн буюу хүүхэд нь нэг нас хүрээгүй, эсхүл хариуцагч хүндээр өвчилсөн тохиолдолд <b>гэрлэлтийг цуцлахыг хориглоно.</b>                                          | 11.2. Эхнэр нь жирэмсэн, эсхүл <ul style="list-style-type: none"> <li>гурван насанд хүрээгүй хүүхэдтэй, эсхүл</li> <li>хүүхэд нь хөгжлийн бэрхшээлтэй, эсхүл</li> <li>гэрлэгчдийн хэн нэг нь хүндээр өвчилсөн, эсхүл</li> <li>хөдөлмөрийн чадвараа хагас, эсхүл бүрэн алдсан тохиолдолд</li> <li>хариуцагч гэрлэлтээ цуцлуулахыг зөвшөөрөөгүй бол гэрлэлт цуцлуулах <b>нэхэмжлэлийг шүүх хэрэгсэхгүй болгоно</b></li> </ul> | 25.4.Энэ хуулийн 25.1-д заасан арга хэмжээг дараах тохиолдолд шүүгч <b>авахгүйгээр гэрлэлтийг цуцалж болно:</b><br>25.4.1.гэрлэгчид эвлэрэх боломжгүй буюу гэрлэгчдийн хэн нэгний байнгын хүчирхийлэл дарамтаас болж гэр бүлийн гишүүдийн амь нас, эрүүл мэнд болон хүүхдийн хүмүүжилд ноцтой аюул, хор уршиг учирч болзошгүй, эсхүл учирсан нь тогтоогдсон; |
| <b>Давхардал:</b> Жирэмсэн боловч байнгын хүчирхийлэл, дарамтад байдаг, эсхүл хүүхэд нь гурван насанд хүрээгүй боловч гэр бүлийн хүчирхийллийн улмаас хор уршиг учирсан тохиолдол. |                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                             |                                                                                                                                                                                                                                                                                                                                                              |
| <b>Тулгамдсан асуудал:</b> <ul style="list-style-type: none"> <li>Хууль хоорондын тодорхойгүй байдал</li> <li>Аль нь давуу хэрэгжих нь тодорхой бус байх</li> </ul>                |                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                             |                                                                                                                                                                                                                                                                                                                                                              |

### 5. Гэр бүлийн эрх зүйн маргааныг шийдвэрлэх шүүх бүрэлдэхүүн

Гэр бүлийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанд шүүх бүрэлдэхүүний асуудлыг Гэр бүл, хүүхэд хамгаалал, шүүхийн харьяаллын тухай хуулийн 13.1 дэх хэсэгт "энэ хуульд заасан гэр бүлийн хэргийг анхан шатны журмаар шүүгч дангаар шийдвэрлэнэ" хэмээн хуульчилсан нь маргааныг нэг шүүгч дангаар шийдвэрлэх зохицуулалтыг тогтоож байна. Энэхүү зохицуулалт нь процессын шуурхай байдлыг хангах зорилготой боловч түүний тодорхой байдал, хэрэгжилтийн чанараас шалтгаалан иргэдийн эрхийн хэрэгжилтэд системийн нөлөө үзүүлэх боломжтой юм. Энэ нь "elevator effect" онолын хүрээнд тайлбарлагдах бөгөөд эрх зүйн орчин оновчтой тохиолдолд эрхийн хэрэгжилтийг дээшлүүлэх, харин тодорхой бус, зөрчилтэй нөхцөлд эсрэгээрээ дордуулах үр дагаварт хүргэж болзошгүй.<sup>13</sup> Гэр бүлийн шүүхийн харьяалан шийдвэрлэх маргааны хүрээ нь зөвхөн гэр бүлийн эрх зүйн харилцаагаар хязгаарлагдахгүй бөгөөд өсвөр насны хүн холбогдсон гэмт хэрэг, мөн тус хуулийн 14.1 дүгээр зүйлийн 1.2, 1.3, 1.5-д заасан таслан сэргийлэх арга хэмжээ, түүнчлэн 31.4, 31.5 дугаар зүйлд заасан баривчлах ажиллагааг хамруулан шийдвэрлэх онцлогтой байна. Иймд шүүгч нь гэр бүлийн иргэний болон эрүүгийн эрх зүйн огтлолцол бүхий асуудлыг нэгэн зэрэг шийдвэрлэх шаардлагатай болж, өндөр түвшний олон талт мэргэшлийг шаардаж байна. Энэ нөхцөлд шүүгч дангаар шийдвэр гаргах тогтолцоо нь онолын хувьд тодорхой эрсдэлийг агуулдаг. Тухайлбал, хамтын шийдвэр гаргалтын онолд дурдсанаар олон шүүгчийн бүрэлдэхүүн нь шийдвэрийг харилцан хянан тэнцвэржүүлэх, алдааг бууруулах давуу талтай байдаг бол нэг шүүгчийн шийдвэр нь тухайн шүүгчийн мэдлэг, туршлага, үнэлэмжээс шууд хамаарах шинжтэй байдаг. Мөн шүүхийн алдааны магадлалын онолоор олон гишүүдтэй бүрэлдэхүүн нь илүү оновчтой шийдвэрт хүрэх магадлал өндөр гэж үздэг бөгөөд эсрэгээрээ нэг шүүгчийн нөхцөлд алдааны эрсдэл нэмэгддэг.<sup>14</sup>

Үүнээс гадна, хууль тогтоомж тодорхой бус, эсхүл давхардсан зохицуулалттай үед шүүгчийн тайлбарлах эрх болон сонгох боломж өргөжиж, энэ нь нэг шүүгчийн шийдвэр гаргалтад субъектив нөлөөлөл нэмэгдэх нөхцөлийг бүрдүүлдэг. Иймд гэр бүлийн хэрэгт шүүгч дангаар шийдвэрлэх зохицуулалт нь зөвхөн процессын хэлбэрийн асуудал бус, харин эрх зүйн тодорхой байдал, шүүхийн шийдвэрийн чанар, улмаар иргэдийн шударга шүүхээр шүүлгэх эрхийн баталгаатай шууд холбоотой онол, практикийн чухал асуудал юм.

<sup>13</sup> Michael J. Nelson, Morgan L. W. Hazelton, The Elevator Effect: Contact and Collegiality in the American Judiciary, 2023, page 5–12.

<sup>14</sup> Lee Epstein, William M. Landes, and Richard A. Posner, The Behavior of Federal Judges, 2013, page 30–45.



*Шигтгээ 3. Шүүгч хамтын зарчмыг баримтлан эрх зүйн маргааныг шийдвэрлэхэд гарах үр нөлөөг тайлбарласан онол*

"Elevator Effect" онол нь эрх зүйн зохицуулалтын үр нөлөөг цахилгаан шатны дээш, доош хөдөлгөөнтэй адил харьцуулан тайлбарладаг. Үүнийг АНУ-ын Холбооны шүүхийн бүх шатны шүүгчдийн зан үйлд хийсэн эмпирик дүн шинжилгээгээр баталгаажуулж, хамтын болон дангаар шийдвэрлэх шүүгчийн шийдвэр гаргалт болон эрхийн хэрэгжилтэд хэрхэн зохицуулалт үзүүлдэг болохыг тайлбарласан онол юм.

**Book by Michael J. Nelson, Morgan L. W. Hazelton, and Rachael K. Hinkle , The Elevator Effect: Contact and Collegiality in the American Judiciary**

**Шийдэл:** Иймд "elevator effect" онол болон харьцуулсан эрх зүйн туршлагаас үзэхэд тухайн хэрэг маргаан нь ээдрээ төвөгтэй, эсхүл эрх зүйн үр дагавар өндөртэй гэж үзсэн тохиолдолд шүүгчийн санаачилгаар бүрэлдэхүүнтэй шүүхээр хянан шийдвэрлүүлэх боломжийг хуульчлан баталгаажуулах нь зүйтэй. Энэ нь нэг талаас шүүхийн шийдвэрийн чанар, үндэслэл бүхий байдлыг нэмэгдүүлэх, нөгөө талаас иргэдийн шударга шүүхээр шүүлгэх эрхийг бодитой хамгаалах нөхцөлийг бүрдүүлнэ.

Мөн гадаад улс орнуудын туршлагаас үзэхэд <sup>15</sup>шүүхийн шийдвэрт давхар хяналт тавих механизмыг бүрэлдэхүүнтэй шүүхийн тогтолцоо болон тодорхойлон нэрлэн заасан маргаанд эсхүл бүхэлд нь давж заалдах шатны хяналтаар дамжуулан хэрэгжүүлдэг нь нийтлэг хандлага байна. Энэ нь шүүхийн алдааг засах, эрхийн зөрчлийг арилгах, хууль хэрэглээний нэгдмэл байдлыг хангах ач холбогдолтой. Гэвч манай улсын ГБХШХШТХ-ийн өргөн мэдүүлсэн төсөлд давж заалдах боломжийг хангалттай түвшинд тусгаагүй байгаа нь шүүхийн шийдвэрт тавих хяналтын тогтолцоог сулруулах, улмаар иргэдийн эрхийг хамгаалах баталгаанд сөргөөр нөлөөлөх эрсдэлтэй байна.

### III. ХАРЬЦУУЛСАН СУДАЛГАА

Олон улсын сайн туршлагыг судалж, зарим төрлийн харилцааг өөрийн орны эрх зүйн зохицуулалтад хөрвүүлэх, хэрэгжүүлэх нь нэг талаас хууль зүйн шинжлэх ухааны хөгжилд хувь нэмэртэй гэж үздэг. Тиймээс энэ хэсэгт олон улсын жишиг тохиолдлыг судлан үзэж, гэр бүлийн эрх зүйн ямар төрлийн харилцаа, хэрхэн шийдвэрлэгдэж, манай улсын эрх зүйн тогтолцоонд нэвтрэх боломжтойг судлах нь ач холбогдолтой.

#### **NEULINGER AND SHURUK v. SWITZERLAND<sup>16</sup>**

**Хэргийн үйл баримт:** Doris Neulinger(цаашид хүүхдийн ээж, эсхүл эх) болон Noam Shuruk(цаашид хүүхдийн аав, эсхүл эцэг) нар нь Израйл улсад бүртгэлтэй гэр бүл юм. Гэр бүл болсон хосууд дундаасаа 1 хүүхэдтэй. Гэвч хүүхдийн эцэг нь Исламын шашны хатуу хэм хэмжээг даган мөрддөг, харин хүүхдийн эх илүү

<sup>15</sup> Japan Family Procedure Act (English), Article 186, 231.

Korea Family Litigation Act (English), Article 20.

<sup>16</sup> European Court of Human Rights. Neulinger and Shuruk v. Switzerland. 06/07/2010 Цахим эрх зүйн эх сурвалжийг бүрэн эхээр нь үзэх холбоос: <https://hudoc.echr.coe.int/eng?i=001-99817> (Сүүлд үзсэн: 2026.03.14).



чөлөөт амьдралын хэв маягийг илүүд үздэг. Энэхүү шалтгаанаас болж хүүхдийн аав, ээж хоорондоо үл ойлголцон гэр бүл цуцлуулдаг. Гэр бүл цуцлуулсны дараагаар хүүхдийн ээж өөрийн бага насны хүүхдийг дагуулан Швейцар улс руу нүүсэн. Гэтэл хүүхдийн аав түүнийг зөвшөөрөлгүй хил дамнуулан авч явсан гэж Хүүхдийг олон улсын хэмжээнд хууль бусаар авч явахтай холбоотой иргэний эрх зүйн асуудлын тухай конвенц(Hague convention of 25<sup>th</sup> October 1980 on the Civil Aspects of International Child Abduction)<sup>17</sup> үндэслэн Израйл улс руу буцаах хүсэлт гаргасан. Швейцар улсын үндэсний шүүх уг нэхэмжлэлийн шаардлагыг хангаж, хүүхдийг Израйл улс руу буцаах шийдвэр гаргасан боловч хүүхдийн ээж энэ шийдвэрийг эсэргүүцэн Европын хүний эрхийн шүүхэд гомдол гаргасан. Харин Европын хүний эрхийн шүүх уг хэргийг шийдвэрлэхдээ хүүхдийг буцаах тохиолдолд хүүхдийн сэтгэл зүй, тогтвортой амьдрал буюу нэгэнт дассан амьдралын хэв маяг нь үүнд сөргөөр нөлөөлж, өөрийн болон гэр бүлийн халдашгүй байдалд нөлөөлөх үйл баримт тогтоогдсон хэмээн үзэж хүүхдийг Швейцар улсад үлдээхээр шийдвэрлэсэн.

Дээрх үйл баримтыг **IRAC(Issue, Rule, Application, Conclusion)**<sup>18</sup> арга зүйг ашиглан дүн шинжилгээ хийе.

### 1. Асуудал (issue)

Хүүхдийг Израил улсаас өөр улс руу хил дамнуулан авч явсан үйл баримт нь маргаан бүхий хэсэг юм.

### 2. Эрх зүйн хэм хэмжээ (rule)

Хүүхдийг олон улсын хэмжээнд хууль бусаар авч явахтай холбоотой иргэний эрх зүйн асуудлын тухай конвенц(Hague convention of 25<sup>th</sup> October 1980 on the Civil Aspects of International Child Abduction)

**3 дугаар зүйл.** Хүүхдийг авч явах буюу саатуулан үлдээх дараах үйлдлийг хууль бус гэж үзнэ. Үүнд:

а)Тухайн хүүхдийн авч явах буюу саатуулан үлдээхээс өмнө байнга оршин сууж байсан улсын хууль тогтоомжийн дагуу нэг этгээд, байгууллага, эсхүл бусад этгээдэд дангаар эсхүл хамтран олгогдсон асран хамгаалах эрхийг зөрчсөн бол;

**12 дугаар зүйл.** Энэ конвенцын 3 дугаар зүйлд заасны дагуу хүүхдийг хууль бусаар авч явсан буюу саатуулан үлдээсэн бөгөөд, тухайн хүүхэд мөн улсад амьдарсан хугацаа 1 жилээс доош байх тохиолдолд хүүхдийг нэн даруй буцаан шилжүүлэхийг шүүх, эсхүл захиргааны байгууллага захирамжилна.

**13 дугаар зүйл.** Өмнөх эрх зүйн зохицуулалтаас үл хамааран, хүсэлт хүлээн авсан улсын шүүх, эсхүл захиргааны байгууллага нь хүүхдийг буцаан шилжүүлэхийг заавал захирамжлах үүрэг хүлээхгүй бөгөөд хэрэв буцаан шилжүүлэхийг эсэргүүцэж буй этгээд, байгууллага, эсхүл бусад этгээд дараах нөхцөлийг нотолбол:

<sup>17</sup> Hague convention of 25<sup>th</sup> October 1980 on the Civil Aspects of International Child Abduction. Цахим эрх зүйн эх сурвалжийг бүрэн эхээр нь үзэх холбоос: <https://www.hcch.net/en/instruments/conventions/full-text/?cid=24> (Сүүлд үзсэн: 2026.03.14).

<sup>18</sup> Touro Law Centre. Work with IRAC. Цахим эх сурвалжийг бүрэн үзэх холбоос: <https://www.tourolaw.edu/adp/studyskills/irac.aspx> (Сүүлд үзсэн: 2026.03.15).



b) Хүүхдийг буцаан шилжүүлэх нь түүнийг бие махбодын эсхүл сэтгэл зүйн ноцтой хохиролд өртүүлэх өндөр эрсдэлтэй, ноцтой аюултай гэж үзсэн тохиолдолд

Хүний эрхийн Европын Конвенц (European Convention on Human Rights)<sup>19</sup>

**8 дугаар зүйл.** Хувийн болон гэр бүлийн амьдралд хүндэтгэл үзүүлэх эрх

Уг эрхийн хэрэгжилтэд төрийн байгууллага оролцохгүй байх бөгөөд зөвхөн хуульд нийцсэн, ардчилсан нийгэмд хэрэгцээтэй, үндэсний аюулгүй байдал, улсын эдийн засгийн сайн сайхан байдал, эмх замбараагүй байдал болон гэмт хэргээс урьдчилан сэргийлэх, эрүүл мэнд ба ёс зүйн хамгаалалт, эсхүл бусдын эрх, эрх чөлөөг хамгаалах зорилгоор зөвшөөрөгдөнө.

### 3. Тохируулга буюу субсумци хийх (application)

Швейцар улсын шүүх Хүүхдийг Олон Улсын Хэмжээнд Хууль Бусаар Авч Явахтай Холбоотой Иргэний Эрх Зүйн Асуудлын тухай Конвенцын 12 дугаар зүйлд тулгуурлан хүүхдийг Израйл улс руу буцаах ёстой гэж шийдвэрлэсэн.

Европын хүний эрхийн шүүх уг хэргийг хянан шийдвэрлэхдээ Швейцар улсын шүүхийн шийдвэртэнцвэртэй байдлыг хангасан эсэхийг шалгасан (**proportionality test**). Өөрөөр хэлбэл, нэг талаас холбогдох журмыг баримталсан байх, нөгөө талаас хүүхдийн эрх ашгийг дээдлэх тухай юм. Ингэхдээ төрийн оролцоог хангасан эсэхийг авч үзэхэд Швейцар улсын шүүх хүүхдийг буцаах шийдвэрийг гаргаж, хууль ёсны эсэхийг шалгахад олон улсын конвенцыг ашигласан нь энэ шатыг хангасан байх боловч 13.b-г дэлгэрэнгүй шалгаж үзээгүй. Үүний дараагаар хүүхдийг буцаах шийдвэр нь шаардлагатай үйлдэл байсан эсэхийг авч үзэхэд, Швейцар улсын шүүх тухайн нөхцөл байдалд хүүхдийн сэтгэл зүйчийг тухайн хүүхэдтэй хамт ажиллуулах, түүнтэй ярилцлага хийх үйл ажиллагааг хийгээгүй хэмээн дүгнэсэн. Тиймээс Европын хүний эрхийн шүүх пропорциональ байх шаардлагыг хангахгүй байхын сацуугаар Хүний эрхийн Европын Конвенцын 8 дугаар зүйлийн дагуу хүүхдийг Швейцар улсад үлдээхээр болсон.

### 4. Явцын дүгнэлт

Европын хүний эрхийн шүүх хүүхдийг Израйл улс руу буцаах шийдвэрийг хүчин төгөлдөр бус болгож, хүүхдийг Швейцар улсад үлдээхээр болсон. Учир нь хүүхдийн ашиг сонирхол нь олон улсын гэрээ болон хүний эрхийн эрх зүйн зохицуулалтаас давуу байна. Мөн түүнчлэн Европын хүний эрхийн шүүх уг хэргийг хянан шийдвэрлэхдээ сэтгэл зүйчийг хүүхэдтэй ажиллуулж, ганцаарчилсан ярилцлага хийхэд хүүхэд нэгэнт Швейцар улсад дасан зохицсон, буцаж Израйл улс руу буцаах нь сэтгэл зүйн хувьд түүнд ноцтой сөрөг үр дагавар авчрах боломжтой гэх агуулга бүхий дүгнэлтийг үндэслэсэн.

Дээр дурдсан шүүхийн шийдвэр нь олон улсын түвшинд хянан хэлэлцэгдсэн сайн туршлагад тооцогдоно. Учир нь гэр бүлийн эрх зүйн маргаан бол нэн тэргүүнд хүүхдийн эрх, ашгийг хүндэтгэдэг байх учиртай. Гэтэл Швейцар улсын шүүх хүүхдийн эрх, ашгийг орхигдуулан зөвхөн эрх зүйн хэм хэмжээнд үндэслэн

<sup>19</sup> European Convention on Human Rights. 1950. Цахим эрх зүйн эх сурвалжийг бүрэн эхээр нь үзэх холбоос: [https://www.echr.coe.int/documents/d/echr/convention\\_ENG](https://www.echr.coe.int/documents/d/echr/convention_ENG) (Сүүлд үзсэн: 2026.03.15).

шийдвэрлэсэн. Хожим Европын хүний эрхийн шүүхийн дурдсаны дагуу Швейцар улсын шүүх тусгай сэтгэл зүйчийг хүүхэдтэй ганцаарчилсан ярилцлага өрнүүлж, хүүхдийн сэтгэл зүйд учрах нөхцөл байдлын тухай дүгнэлтийг харгалзах шаардлагатай байсныг дурдсан. Энэ зэргээс үзэхэд, дээрх шүүхийн шийдвэрийн гол сургамж бүхий зохицуулалт нь 1/хүүхдийн эрх, ашгийг олон улсын хэм хэмжээнээс илүүд үзэх, 2/шүүх эрх мэдэл бүхий институт бүрд хүүхдийн сэтгэл зүйчийг ажиллуулах зэрэг байна.

#### IV. ДҮГНЭЛТ, САНАЛ

Гэр бүлийн харилцаа нь нийгмийн суурь асуудал болохын сацуу дэлхийн аль ч цаг үед түүний эрх зүйн харилцаа хувьсан өөрчлөгдөж байдаг тул тухайлан зохицуулсан хэм хэмжээг боловсронгуй болгох шаардлага ямагт тулгардаг. Жишээлбэл, Эртний Грек-т уламжлал, ёс суртахууны хэм хэмжээнд тулгуурлаж уг харилцааг зохицуулдаг байсан бол Дундад зууны Европт гэр бүлийн харилцааг шашны нөлөө дор зохицуулах болсон. Харин орчин үеийн хууль зүйн шинжлэх ухаанд гэр бүлийн эрх зүй нь хүний эрхийн үзэл баримтлалтай нягт уялдаж хөгжсөн. Тухайлбал, Хүний эрхийн түгээмэл тунхаглал-д гэр бүл нь нийгмийн үндсэн нэгж болохыг хүлээн зөвшөөрч, мөн харилцаанд төр оролцох, ингэхдээ хамгаалах механизмыг хэрэгжүүлэх шаардлагатайг тунхагласан. Үүний нэгэн адил Монгол Улсын хувьд гэр бүлийн эрх зүйн хөгжил нь уламжлалт зан заншил, социалист үеийн хууль тогтоомж, ардчилсан дэглэмийн шинэчлэлийн үе шаттайгаар хөгжиж ирсэн ба эдүгээ гэр бүлийн эрх зүйн харилцааг ҮНХ(1992), Гэр бүлийн тухай хууль(1999), Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх тухай хууль(2016), Хүүхдийн эрхийн тухай хууль(2016), Хүүхэд хамгаалах тухай хууль(2024) зэрэг эрх зүйн хэм хэмжээгээр зохицуулж байна. Гэвч эдгээр эрх зүйн үйлчлэлтэй хууль тогтоомж нь зарим харилцааг орхигдуулж, хуулийн хийдэлтэй нөхцөл байдлыг үүсгээд буйг нэрт судлаачид цохон тэмдэглэж, практик шаардлага нэгэнт үүссэн. Иймээс Монгол Улсын Засгийн газар 2025 оны 11-р сарын 14-ны өдөр ГБХШХШТХ болон ГБТХ-ийн төслүүдийг өргөн мэдүүлж эрх зүйн шинэчлэлийг бий болгохыг зорьсон байна. Угтаа хуучин хууль тогтоомжийг шинэчлэн, зарим орхигдсон эрх зүйн харилцааг үндсэн зарчим, үзэл баримтлалтай нийцүүлэн төсөл боловсруулсан байх боловч одоог хүртэл хууль хоорондын зөрчилдөөн, тодорхойгүй байдал, шүүмжлэлтэй хандах эрх зүйн зохицуулалт байгааг энэхүү эрдэм шинжилгээний илтгэлийн хүрээнд илрүүлэв. Үүний үр дүнд Хууль тогтоомжийн тухай хуулийн 4.1 дүгээр зүйлийн 5 дугаар хэсэгт заасны дагуу хуулийн төсөл нь судалгаа, шинжилгээнд үндэслэсэн байх зарчмыг хангахгүй байна. Тиймээс судлаач оюутнуудын зүгээс уг өргөн мэдүүлсэн эрх зүйн төслийг илүү боловсронгуй болгох зорилгоор социаль судалгааны тоон болон чанарын арга зүйг ашиглан дээрх 5 асуудлыг хөндөн дэлгэрэнгүй судалсан бөгөөд гол судлагдахуунтай холбогдуулан бусад улсын сайн туршлагыг судалж, жишиг шүүхийн шийдвэрийг авч үзсэний үр дүнд дараах саналыг дэвшүүлж байна.



### Хүснэгт 3. Дэвшүүлсэн асуудал бүр дээр шийдэл гарган тайлбарласан байдал

| Дэвшүүлсэн асуудал                                                                   | Шийдэл                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                      |
|--------------------------------------------------------------------------------------|---------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------|
| Хүүхэд оролцсон гэр бүлийн маргаанд сэтгэл зүйч зайлшгүй оролцох тухай               | Хүүхэд оролцсон гэр бүлийн маргаанд зайлшгүй сэтгэл зүйч томилж хүүхдийн эрх, ашиг сонирхлыг бодитой хамгаалах;<br><br>ONE CHILD-ONE PSYCHOLOGIST зарчмыг баримтлан шүүхийн ажлын байранд сэтгэл зүйч мэргэжлийг оруулах;                                                                                                                                                                   |
| Гэр бүлийн хүчирхийлэл үйлдэх гэмт хэргийг гэрлэлт цуцлах маргаантай хамт шийдвэрлэх | ГБХШХШТХ-д гэр бүлийн хүчирхийлэл үйлдэх гэмт хэрэг болон уг маргаанаас үүдэн гэр бүл цуцлуулах тухай хүсэлтийг нэг дор, эсхүл тусдаа шүүхийн процесс ажиллагаа явуулж хэрэгжүүлэх эсэх зэрэг эрх зүйн зохицуулалтыг бий болгох                                                                                                                                                             |
| "Гэр бүлтэй адилтгах орчин"-г тодорхойлох нь                                         | "Хүүхэд өөрийн төрсөн эцэг, эхийн асрамжид амьдрах боломжгүй нөхцөлд түүнд гэр бүлийн орчинтой адил нөхцөлд асран хамгаалж, халамжилж, хүмүүжүүлэх зорилгоор бүрдүүлсэн орчинг хэлнэ", эсхүл "Хүүхэд төрсөн эцэг, эхийн асрамжид амьдрах боломжгүй тохиолдолд түүний эрх, ашгийг хангах зорилгоор асран хамгаалж, халамжилж, хүмүүжүүлэхээр зохион байгуулсан орчинг ойлгоно" гэж томъёолох |
| Хууль хоорондын тодорхойгүй байдал                                                   | ГБТХ-ийн шинэчилсэн найруулгын 11.2 дугаар зүйл болон ГБХШХШТХ-ийн 25.4 дугаар зүйлийн давхардлыг арилгах, боловсронгуй болгох                                                                                                                                                                                                                                                              |
| Гэр бүлийн эрх зүйн маргааныг шийдвэрлэх шүүх бүрэлдэхүүн                            | Тухайн хэрэг маргаан нь ээдрээ төвөгтэй, эсхүл эрх зүйн үр дагавар өндөртэй гэж үзсэн тохиолдолд шүүгчийн санаачилгаар бүрэлдэхүүнтэй шүүхээр хянан шийдвэрлүүлэх боломжийг хуульчлан баталгаажуулах;<br><br>Давж заалдах эрх зүйн боломжийг хуульчлах                                                                                                                                      |



## НОМ ЗҮЙ

### 1. Эрх зүйн эх сурвалж:

1. Үндсэн хууль, 1992 он.
2. Гэр бүлийн тухай хууль, 1999 он.
3. "Гэр бүлийн тухай" хуулийн шинэчилсэн найруулга /өргөн мэдүүлсэн хуулийн төсөл/, 2025 оны 11 сарын 14.
4. "Гэр бүлийн хэрэг хянан шийдвэрлэх тухай" хууль / өргөн мэдүүлсэн хуулийн төсөл /, 2025 оны 11 сарын 14.
5. Хууль тогтоомжийн тухай хууль, 2015 он.
6. Хүүхэд хамгааллын тухай хууль, 2024 он.
7. European Convention on Human Rights, 1950 он.

### 2. Монгол хэл дээрх эх сурвалж:

1. Монгол Улсын Дээд Шүүх. Гэр бүлийн хүчирхийлэл үйлдэх гэмт хэргийг хянан шийдвэрлэх ажиллагаа, тулгамдаж буй бэрхшээл, бодлогын шинэчлэл, 2025 он.
2. Улсын Ерөнхий Прокурорын газрын дэргэдэх сургалт, судалгааны хүрээлэн, *Гэр бүлийн хүчирхийллийн улмаас хүүхэд хохирсон гэмт хэргийн гаралт, шийдвэрлэлт, шалтгаан, нөхцөл*, 2022 он.
3. С.Жанцан, *Криминологи*, 2000 он.

### 3. Гадаад хэл дээрх эх сурвалж:

1. European Court of Human Rights. Neulinger and Shuruk v. Switzerland. 06/07/2010, <https://hudoc.echr.coe.int/eng?i=001-99817>
2. Hague convention of 25<sup>th</sup> October 1980 on the Civil Aspects of International Child Abduction. Цахим эрх зүйн эх сурвалжийг бүрэн эхээр нь үзэх холбоос: <https://www.hcch.net/en/instruments/conventions/full-text/?cid=24>
3. Lee Epstein, William M. Landes, and Richard A. Posner, *The Behavior of Federal Judges*, 2013
4. Michael J. Nelson, Morgan L. W. Hazelton, *The Elevator Effect: Contact and Collegiality in the American Judiciary*, 2023
5. Penn state university libraries, "Empirical Research in the Social Sciences and Education", <https://guides.libraries.psu.edu/emp>
6. Touro Law Centre. Work with IRAC. <https://www.tourolaw.edu/adp/studyskills/irac.aspx>
7. Japan Family Procedure Act (English)
8. Korea Family Litigation Act (English)
9. Kristine D. Frankenberger, *"Adolescent egocentrism: a comparison among adolescents and adults,"* 2000.
10. Saul McLeod, *Erik Erikson's Stages of Psychosocial Development*, 2025.

1.



#### 4. Цахим эх сурвалж

1. Монгол Улсын эрх зүйн мэдээллийн нэгдсэн систем: <https://legalinfo.mn/mn>.
2. Европын хүний эрхийн шүүхийн цахим хуудас: [https://hudoc.echr.coe.int/#{%22documentcollectionid2%22:\[%22GRANDCHAMBER%22,%22CHAMBER%22\]}](https://hudoc.echr.coe.int/#{%22documentcollectionid2%22:[%22GRANDCHAMBER%22,%22CHAMBER%22]}).
3. "Penn state" их сургуулийн цахим хуудас: <https://libraries.psu.edu/>.
4. "Touro Law Center" хууль зүйн сургуулийн цахим хуудас: <https://www.tourolaw.edu/>.



## Refining the legal framework of family relations: A critical review of the draft Family law and the draft law on Family case proceeding

ANUJIN Tuvshinjargal\*

JAVZMAA Erdene-Ochir\*\*

**Abstract:** The family is the primary unit of human society. In this sense, family relations serve as the fundamental environment for human life and are a core relationship protected by the Constitution. For instance, Article 16.13 of the Constitution of Mongolia explicitly safeguards the "inviolability of personal and family life." This underscores that family relations are undeniably the most sacred, essential, and inviolable aspects of human existence.

Compared to other legal branches, family law involves a relatively low degree of legal coercion and is more private in nature, as it regulates relations between vulnerable social groups, such as children and parents. However, despite Mongolia's transition to a democratic system, the legal framework established by the 1999 Family Law has remained largely unchanged for 27 years, leaving several contemporary family relations unregulated. Furthermore, resolving family disputes within the general civil, criminal, and administrative court systems often fails to uphold the "best interests of the child" principle due to the absence of specialized procedural regulations. Consequently, there is an urgent need to align these unique relations with more sophisticated fundamental principles.

The Government of Mongolia submitted the draft revision of the Family Law on November 14, 2023, and the draft Law on Family Case Proceedings on November 14, 2025. Nevertheless, certain legal relations remain overlooked in these drafts, necessitating further refinement of specific norms. Therefore, this study utilizes empirical social research methodology to address the issues within the submitted drafts and seeks to propose viable legal solutions.

**Keywords:** Family law, family case proceedings, psychologist, family-like environment, domestic violence, citizen representatives, closed-court session, judicial panel, legislative draft

---

\* 4th grade student of School of law, National University of Mongolia.  
\* 4th grade student of School of law, National University of Mongolia.